



**ИНШҮРКО**  
ДААТГАЛ

*Эрсдэлтэйгээр уратшигъя*

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2024



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Иншүрко даатгал ХХК-ийн үйл ажиллагааны тайлантай танилцаж буй эрхэм харилцагч, хамтран ажиллагч та бүхний амар, амгаланг айлтган мэндчилье.

Олон улсын даатгалын салбар эрчимтэй хөгжиж, технологийн дэвшил, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, эрсдэлийн менежментийн шинэ хандлагаар улам боловсронгуй болж байна.

Түүнчлэн эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт, кибер аюулгүй байдал зэрэг олон талт эрсдэл нэмэгдэхийн хэрээр даатгал нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах стратегийн чухал хэрэгсэл болсоор байна.

Монгол улсын хувьд даатгалын салбарын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн удирдлага, олон улсын чиг хандлага, цаг үеийн шаардлагад нийцсэн орчныг бүрдүүлэх зорилгоор салбарын хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулахад голчлон анхаарч байна.

Иймд бид эрсдэлийг зөв удирдах, найдвартай хамгаалалт үзүүлэх, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүндэтгэсэн,

**Н.ГАНБЯМБА**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм харилцагчид, хамтран ажиллагсад, даатгалын салбарын эрхэмсэг төлөөлөгчид өө!

"Иншүрко даатгал" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш үйл ажиллагаагаа тэлж, харилцагчдынхаа хэрэгцээнд бүрэн нийцсэн даатгалын үйлчилгээг хүргэж байгаадаа баяртай байна.

Манай улсын хувьд даатгалын салбар хөгжлийн шинэ шатанд гарч, санхүүгийн системийн салшгүй бүрэлдэхүүн болон хөгжиж байхын зэрэгцээ эдийн засгийн өсөлт, бизнесийн орчны тэлэлттэй уялдан даатгалын эрэлт хэрэгцээ нэмэгдэж, иргэн болон байгууллагын санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалах чухал механизм болж байна.

Манай байгууллага нь даатгуулагчийн эрсдэлийг оновчтой удирдах, хохирлыг хурдан шуурхай нөхөн төлөх, урьдчилан сэргийлэх, зөвлөж чиглүүлэх, даатгалын цогц үйлчилгээ үзүүлсэн баялаг бүтээгч хүн бүрийн зорилтот сонголт байхаар зорин ажиллаж байна.

Мөн бид цаашид зөвхөн даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгаад зогсохгүй, таны найдвартай түнш, итгэлийг тань хүлээсэн хамтрагч, хариуцлагыг эрхэмлэгч байхыг зорин ажиллах болно.

Хүндэтгэсэн,

**Б.СОЛОНГО**

Гүйцэтгэх захирал



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### ЕРДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГДОВ.

Иншүрко даатгал ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр байгуулагдаж, Санхүүгийн зохицуулах хорооны 94 дүгээр тогтоолоор 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аван Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.




### МОНГОЛЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХОЛБООНД ГИШҮҮНЭЭР ЭЛСЭВ.

2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн “Монголын даатгалын зах зээлийн холбоо” НҮТББ-ийн Бүх гишүүдийн хурлаар гишүүнээр элсэв.



### “НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ДАРХЛАА - ДААТГАЛ” ФОРУМД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ.

Монгол улсад даатгалын тогтолцоо үүсэж бэхэжсэний 90 жилийн ойн хүрээнд "Дижитал галерей" цогц арга хэмжээнд амжилттай оролцлоо. "Дижитал галерей" цогц арга хэмжээний үеэр "Нийгэм эдийн засгийн дархлаа - Даатгал" зохицуулалтын дунд хугацааны бодлогыг тодорхойлох форум, "Дижитал галерей" - Даатгалын салбарын түүхэн замнал, даатгалын салбарын дижитал болон инноваци шийдлүүд, Монгол Улсын нийгмийн орчны ТОП эрсдэлийн талаарх ойлголт танилцуулга, Да Винчи уран зургийн дижитал цомог зэрэг 360 хэм визуаль үзвэрүүд, Монгол Улсын нийгмийн орчин дахь ТОП эрсдэлийн танилцуулга, түүнийг хэрхэн даван туулах шийдлүүд зэрэг үйл ажиллагаа өрнөсөн. Бид ТОП-4 эрсдэлийн “Эрүүл мэндийн эрсдэл” хэсэгт “Стресс менежмент” сэдэвт сургалтыг мэргэжлийн сэтгэл зүйчтэй хамтран танилцууллаа.





## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### **БАТАЛГААНЫ ЗӨВЛӨЛД ГИШҮҮНЭЭР ЭЛСЭЖ, ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ХИЙЖ ЭХЛЭВ.**

Бид Баталгааны зөвлөлд элсэж, Даатгагчийн баталгаа болох Тендерийн баталгаа, Гүйцэтгэлийн баталгаа, Урьдчилгаа төлбөрийн баталгаа, Чанарын баталгааг хууль журмын дагуу хийж байна.

Үүний хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны газартай гэрээ байгуулан худалдан авах ажиллагааны цахим систем, даатгагчийн баталгааны мэдээллийн сан хоорондын мэдээлэл солилцон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тендер сонгон шалгаруулалтад оролцогчдын тендерийн баталгааг хийж байна.



### **"MF3 ФАНКШЕНЛ ФИТНЕССИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024"-Д ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР ОРОЛЦОВ.**

2024 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Дасгал хөдөлгөөнийг эрүүл амьдралын хэв маяг болгосон залуучуудын тэсвэр тэвчээрийн асар том сорил болсон тэмцээн болох "MF3 Фанкшенл Фитнесийн улсын аварга шалгаруулах тэмцээн"-д бид ивээн тэтгэгчээр хамтран ажиллалаа.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Иншүрко даатгал ХХК-ийн дүрмийн 7.1-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчийн чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байх бөгөөд ТУЗ-ийн дарга, гишүүдэд тавих шаардлагыг хангасан нийт 5 гишүүнтэйгээр тайлант онд ажилласан.



**Н.Ганбямба**

ТУЗ-ийн дарга



**Ш.Жаргалсайхан**

ТУЗ-ийн гишүүн



**Б.Солонго**

ТУЗ-ийн гишүүн



**Д.Төмөрчөдөр**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн



**Г.Янжмаа**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ 3 хороотой бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон байдаг.

ТУЗ-ийн дэргэдэх хороод	Үндсэн чиг үүрэг	Бүтэц, бүрэлдэхүүн
Аудит, эрсдэлийн удирдлагын хороо	Компанийн санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, их дүнтэй болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл, дотоод аудитын үйл ажиллагаа, хууль, дүрэм журмын хэрэгжилтэд компанийн зүгээс хяналт тавих	Дарга Ш.Жаргалсайхан Гишүүн Д.Төмөрчөдөр Гишүүн Г.Янжмаа
Хүний нөөц, нэр дэвшүүлэх хороо	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх	Дарга Д.Төмөрчөдөр Гишүүн Н.Ганбямба Гишүүн Б.Солонго
Цалин урамшууллын хороо	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулж, хяналт тавих, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах	Дарга Г.Янжмаа Гишүүн Ш.Жаргалсайхан Гишүүн Н.Ганбямба



## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



**Б.Солонго**

Гүйцэтгэх захирал



**У.Тамир**

Даатгалын газрын  
захирал



**О.Нарангэрэл**

Эрсдэлийн газрын  
захирал



**Д.Уянга**

Үйл ажиллагааны  
газрын захирал




**А.Анар**

Санхүү удирдлагын  
газрын захирал



## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖИЛ

2024 онд бид Даатгалын тухай хууль болон Даатгалын багц дүрэмд нийцүүлэн зах зээлд борлогдох даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж, нийт 11 хэлбэрийн 34 бүтээгдэхүүнийг авч ажиллаа. Үүнд



**ГЭНЭТИЙН ОСОЛ,  
ЭМЧИЛГЭЭНИЙ  
ДААТГАЛ**



**АВТО ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЛИЙН  
ДААТГАЛ**



**ХӨРӨНГИЙН  
ДААТГАЛ**



**ХАРИУЦЛАГЫН  
ДААТГАЛ**



**АЧААНЫ  
ДААТГАЛ**



**ЗЭЭЛИЙН  
ДААТГАЛ**




**БАРИЛГА УГСРАЛТЫН  
ДААТГАЛ**



**АГААРЫН ХӨЛГИЙН  
ДААТГАЛ**



**АГААРЫН  
ХӨЛГИЙГ  
ӨМЧЛӨХ,  
ЭЗЭМШИХ,  
АШИГЛАХТАЙ  
ХОЛБООТОЙ  
ХАРИУЦЛАГЫН  
ДААТГАЛ**



**ТӨМӨР ЗАМЫН  
БОЛОН УСАН  
ЗАМЫН ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЛИЙН  
ДААТГАЛ**



**ТӨМӨР ЗАМЫН  
ЭСХҮЛ УСАН  
ЗАМЫН ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЛИЙГ  
ӨМЧЛӨХ,  
ЭЗЭМШИХ,  
АШИГЛАХТАЙ  
ХОЛБООТОЙ  
ХАРИУЦЛАГЫН  
ДААТГАЛ**



## ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Байгууллагын даатгал

157.5 сая ₮

Хураамжийн орлого

14

Гэрээний тоо

### Иргэдийн даатгал

275.1 сая ₮

Хураамжийн орлого

2383

Гэрээний тоо

## БАНКАШУРАНС

Бид зах зээлд "банкашуранс" буюу банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран даатгалын үйлчилгээг улам бүр төгөлдөржүүлэн, хэрэглэгчдэд илүү хялбар, найдвартай шийдлүүдийг санал болгож байна.

Монголын тэргүүлэх банкнууд болон ББСБ-уудтай (банк бус санхүүгийн байгууллагууд) хамтран банкашурансийн үйлчилгээний цар хүрээг тэлж, харилцагчдад зориулсан олон талын цогц үйлчилгээ үзүүлж байна.

Үүний хүрээнд банк болон ББСБ-ийн ажилтнуудад даатгалын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, бүтээгдэхүүн бүрийн онцлог, хэрэглээнд тохирсон шийдлүүдийг зөвөөр хүргэх зорилгоор сургалт, мэдлэг олгох хөтөлбөрүүдийг тогтмол зохион байгуулж ажиллаа.

Тайлант онд хамтран ажиллаж буй банк болон ББСБ-уудын ажилтнуудад зориулсан нийт 13 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулж, 640 орчим ажилтныг хамруулаад байна. Эдгээр сургалтууд нь зөвхөн ажилтнуудын мэдлэгийг нэмэгдүүлэхэд бус, хэрэглэгчдэд илүү ойлгомжтой, хэрэгцээтэй мэдээллийг хүргэх, мэргэжлийн түвшинд зөвлөгөө өгөх чадварыг дээшлүүлж байна.



## НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн нөхөн төлбөрийн нэгж нь Монгол улсын болон зохицуулагч байгууллагын журам болон компанийн дотоод дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайланд онд нийт 2 нөхөн төлбөрийг ажлын 1 хоногт багтаан түргэн шуурхай шийдвэрлэж олгосон. Нийт шийдвэрлэгдсэн нөхөн төлбөрийг 100 хувь тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн эзэлж байна.

Харилцагчаас нөхөн төлбөрийн үйл ажиллагааны талаар санал гомдол ирээгүй бөгөөд түргэн шуурхай шийдвэрлэсэн тал дээр талархал хүлээн авч ажиллаа.

Даатгалын нөхөн төлбөрийг бид цахимаар хүлээн авч, даатгуулагчид хүндрэл чирэгдэл учруулалгүйгээр түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.

# 2

Нийт олгосон нөхөн төлбөр


# 1.2 сая ₮

Нийт олгосон нөхөн төлбөр /дүнгээр/

# 1 хоног

Нөхөн төлбөр олгосон дундаж хугацаа

## НӨХӨН ТӨЛБӨРИЙН ПРОЦЕСС



01

Даатгалын тохиолдол үүсэх



02

Иншүрко даатгал ХХК руу холбогдож даатгалын тохиолдлын талаар мэдээллэх



03

Даатгалын тохиолдол нотолгоожуулах (Онлайн үзлэг болон биет үзлэг)



04

Нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх (Цахимаар болон эх хувиар)



05

Нөхөн төлбөрийн шийдвэрлэлт, олголт



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Даатгалын салбарын үйл ажиллагаа нь өөрийн онцлог бүхий бусдын эрсдэлийг өөртөө шилжүүлдэг салбар бөгөөд түүний төлөө тухайн байгууллагын үйл ажиллагаанд эргээд олон төрлийн эрсдэл тулгарч байдаг.

Бид Эрсдэлийн удирдлагын бодлогыг баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн баталсан ба эрсдэлийн хороог мөн байгуулан ажиллаж байна.

Манай компани эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Эрсдэлийн газраас болон нийт ажилчид эрсдэлийг тодорхойлон, шинжилж, тохирсон удирдлагыг Эрсдэлийн хорооноос өгсөн үүргийн дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

“Иншүрко даатгал” ХХК нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ анхлан эрсдэлийн үнэлгээ хийдэг бөгөөд эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх, эдгээр үйл явц эргэн давтагдах юм. Эргэн давтагдах эрсдэлүүдийг дахин үнэлэх нь уг эрсдэлийн удирдах арга хэрэгслийг өөрчлөх шаардлагатай эсэхийг шалгах ач тустай юм. “Иншүрко даатгал” ХХК-ийн эрсдэлийн удирдлага нь дараах үндсэн 5 процессоос бүрддэг.





Эрсдэлийг тодорхойлох нь нийт ажилчдын үүрэг бөгөөд манай компанид үүсэж болох эрсдэл, түүний шинжилгээг бид бүхий л түвшний ажилчдад эрсдэлийн шинжээчийн зүгээс үнэлэх боломжийг бий болгон ажилладаг.

Уг үнэлгээгээр гарсан эрсдэлийг удирдах арга хэрэгслийг эрсдэлийн хороо шийдвэрлэдэг бөгөөд арга хэрэгслийн хэрэгжилтэд эрсдэлийн газар хяналт тавин жилдээ 2 удаа Эрсдэлийн хороонд тайлагнадаг байна. Манай компани эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх хамгаалалтын 3 шугамтай.

<b>Хамгаалалтын нэгдүгээр шугам</b>	Компанийн газар, нэгжийн бүх ажилтнууд
<b>Хамгаалалтын хоёрдугаар шугам</b>	Эрсдэл хариуцсан газар, хэлтэс
<b>Хамгаалалтын гуравдугаар шугам</b>	Эрсдэлийн хороо

Бид эрсдэлийг 2 төрөл болон 5 ангилалд хуваадаг Үүнд:

<b>Эрсдэлийн төрөл</b>	<b>Эрсдэлийн ангилал</b>
<ul style="list-style-type: none"><li>Гадаад эрсдэл</li><li>Дотоод эрсдэл</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээний эрсдэл</li><li>Стратегийн эрсдэл</li><li>Холбоотой талуудын эрсдэл</li><li>Санхүүгийн эрсдэл</li><li>Үйл ажиллагааны эрсдэл</li></ul>

Эрсдэлийг үнэлэхдээ бид 1984 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж буй "Bickmore risk Services" болон Калифорнийн их сургуулийн Ерөнхийлөгчийн Эрсдэлийн газартай хамтран гаргасан "Enterprise risk management" үнэлгээг жишиг болгон ашигладаг бөгөөд "Иншүрко даатгал" ХХК-ийн эрсдэлүүдийг таних, түүний нөлөөллийг тооцоолох, харьцуулах, эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг санал болгох зорилгоор уг эрсдэлийн үзүүлж болох хохирлыг бүхий талаас нь судалдаг. Нэр хүндийн хохирол, санхүүгийн хохирол, болон хүний эрүүл мэнд, амь насанд үзүүлэх хохирол гэсэн 3 үзүүлэлт ордог. Эдгээр 3 үзүүлэлтийг ашиглан эрсдэлийг үнэлэх нь эрсдэлүүдийг хооронд нь харьцуулж болох давуу талыг бий болгодог. Харин хугацааны хувьд давтамжаас гадна эрсдэл хэр хурдан бий болдгоос хамааруулан ялгаатай байдлаар үнэлдэг.

"Иншүрко даатгал" ХХК нь эрсдэлийг оновчтой тодорхойлж, үнэлэн, удирдлагын арга хэрэгслийг хэрэгжүүлснээр байгууллагын эрсдэлийг бууруулахад чиглэсэн үр дүнтэй бодлого баримтлахыг эрхэмлэдэг бөгөөд цаашид эрсдэлийн удирдлагын арга барилыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлснээр даатгалын салбарын тогтвортой байдал, өсөлтийг хангахад хувь нэмрээ оруулах юм.



## ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

# 29

Дундаж нас

# 17

Ажилтны тоо

Компанийн хүний нөөцийн бодлого нь компанийн үнэт зүйл болох ажилтан бүрийн мэргэжил, ур чадварт тулгуурласан чадварлаг багийн ажиллагааг орчин үеийн хүний нөөцийн менежментийн аргатай хослуулж, бизнесийн урт хугацааны тогтвортой амжилтыг бий болгоход оршдог.

# 4

Салбарын  
шагналаар  
шагнагдсан  
ажилтан

# 44%

Эмэгтэй ажилтны  
эзлэх хувь

Бид даатгалын салбар төдийгүй банк санхүүгийн салбарын туршлага, ур чадвар бүхий мэргэжилтнүүдийг нэгтгэн, чадварлаг хүний нөөцөөр багаа бүрдүүлэн ажиллаж байна.

Компанийн ажилчдын 56 хувийг эмэгтэй ажилчид бүрдүүлж байгаа нь Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хангаж байна.

## Ажилтны сургалт, хөгжил

### Chartered Insurance Institute (CII)-ийн 5 багц хичээлийн сургалт

2024.10.24-2024.10.30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг GIZ Mongolei, DeveloPPP, Монре даатгал нарын хамтран хэрэгжүүлж буй "ISBC" төслийн хүрээнд Chartered Insurance Institute (CII)-ийн 5 багц хичээлийн сургалт

### Шинэ ажилтны сургалт

2024.10.31-2024.11.01-ний өдрүүдэд "Монголын даатгалын зах зээлийн холбоо" НҮТББ-аас зохион байгуулсан даатгалын салбарын "Шинэ ажилтны сургалт"

### Хөрөнгийн Даатгалын Андеррайтинг ба Эрсдэлийн Удирдлага

2024.09.10-ны өдөр Смарт Сонголт Даатгал/Давхар даатгалын брокер, Монголын даатгалын холбоо болон Tyser Risk Management Bangladesh Limited - TRMBL нарын хамтарсан "Хөрөнгийн Даатгалын Андеррайтинг ба Эрсдэлийн Удирдлага" сэдэвт семинар

### Компанийн засаглалын сургалт

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос зохион байгуулдаг "Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт"



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### ОЮУТАН-АЖИЛТАН

Бид дотоодын их, дээд сургуулиудын оюутан залуусыг тухайн суралцаж буй мэргэжлийн чиглэлээр, уян хатан ажлын цагийн нөхцөлтэйгөөр, өөрсдийн компанид үндсэн ажилтнаар ажиллуулж байна.

Энэ нь оюутнуудад өөрийн мэргэжил, ур чадвараа бодит ажил дээр хэрэгжүүлэх боломж олгох төдийгүй, сурч мэдсэн зүйлсийг практик дээр ашиглах чадварыг нь хөгжүүлж, ажлын орчны талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлдэг.

Мөн энэ арга хэмжээ нь их, дээд сургуулиудын дадлагын тогтолцоог сайжруулах, оюутнуудад ажлын байранд суурилсан сургалт, дадлагын хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр сургалтын системийг бодит амьдралтай холбох, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний ажлын орчинд шаардагдах ур чадварыг хурдан хугацаанд эзэмших нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү оролцоо нь төгсөгчдийг нийгэмд гарах болон ажилд орох үйл явцыг хурдасгах, тэдний хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг билээ.





## ТАЙЛАНТ ОНД ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУД

### Хамтран ажиллагч давхар даатгал, даатгалын брокер



### Хамтран ажиллагч банкууд



### Хамтран ажиллагч банк бус санхүүгийн байгууллагууд



www.insurco.mn

### Хамтран ажиллагч бусад байгууллагууд





## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“ИНШҮРКО ДААТГАЛ” ХХК**

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар  
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Улаанбаатар хот

2025 он



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН  
2024 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>		
1.1.1	Бэлэн мөнгө	100,000.00	150,280,000.00
1.1.2	Харилцахад байгаа мөнгө		60,754,034.92
1.1.3	Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө		
	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн</b>	<b>100,000.00</b>	<b>211,034,034.92</b>
<b>1.2</b>	<b>Даатгалын авлага</b>		
1.2.1	Даатгалын хураамжийн авлага		79,740,220.00
1.2.2	Буруутай этгээдээс авах авлага		
1.2.3	Давхар даатгалаас авах авлага		
	<b>Даатгалын авлагын дүн</b>		<b>79,740,220.00</b>
<b>1.3</b>	<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>		
1.3.1	Бусад авлага		118,739.32
	<b>Бусад санхүүгийн хөрөнгийн нийт дүн</b>		<b>118,739.32</b>
<b>1.4</b>	<b>Бусад санхүүгийн бус хөрөнгө</b>		
1.4.1	НДШ-ийн авлага, бусад татварын авлага		
1.4.2	ААНОАТатварын авлага		
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө		76,223,237.47
1.4.4	Бараа материал		34,057,500.00
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		146,902,528.70
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө		
	<b>Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн</b>		<b>257,183,266.17</b>
<b>1.5</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>		
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат		5,051,240,004.06
1.5.2	Үнэт цаас		
	<b>Хөрөнгө орлуулалтын дүн</b>		<b>5,051,240,004.06</b>
<b>1.6</b>	<b>Даатгалын хөрөнгө</b>		
1.6.1	Хойшлогдсон давхар даатгалын хураамж		
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг		
1.6.3	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэл		
	<b>Даатгалын хөрөнгийн дүн</b>		
<b>1.7</b>	Үндсэн хөрөнгө/Цэвэр/		34,974,857.88
<b>1.8</b>	Биет бус хөрөнгө/Цэвэр/		14,116,666.64
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>100,000.00</b>	<b>5,648,407,788.99</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Даатгалын өглөг</b>		
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг		
2.1.1.3	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг		4,794,688.85
	<b>Даатгалын өглөгийн дүн</b>		<b>4,794,688.85</b>
<b>2.1.2</b>	<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>		
2.1.2.6	Бусад өр төлбөр		48,164,605.00



## Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

	<b>Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн</b>		<b>48,164,605.00</b>
<b>2.1.3</b>	<b>Бусад санхүүгийн бус өр төлбөр</b>		
2.1.3.1	Цалингийн өглөг		46,285.72
2.2.3.2	НДШ-ийн өглөг		12,695,961.59
2.1.3.3	ААНОАТатварын өглөг		
2.1.3.4	Хойшлогдсон татварын өглөг		
2.1.3.5	Урьдчилж орсон орлого		
2.1.3.6	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр		
2.1.3.11	Бусад санхүүгийн бус өр төлбөр		22,975,894.65
	<b>Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн</b>		<b>35,718,141.96</b>
<b>2.1.4</b>	<b>Орлогод тооцоогүй хураамжийн нөөц</b>		<b>313,277,943.45</b>
2.1.5	Хоёрдогч өглөг, хүү		
<b>2.1.6</b>	<b>Нөхөн төлбөрийн нөөц сан</b>		
2.1.6.1	Учирсан боловч мэдэгдээгүй ХНС		67,064,304.32
2.1.6.2	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан		662,500.00
2.1.6.3	Учирч болзошгүй хохирлын нөөц сан		90,084,783.73
2.1.6.4	Тусгай нөөц сан		
	<b>Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн</b>		<b>157,811,588.05</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>559,766,967.31</b>
<b>2.2</b>	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.2.1	Эздийн өмч	100,000.00	5,000,000,000.00
2.2.2	Эздийн өмчийн бусад хэсэг		197,000,000.00
2.2.3	Хуримтлагдсан ашиг/алдагдал		(108,359,178.32)
	<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>100,000.00</b>	<b>5,088,640,821.68</b>
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>100,000.00</b>	<b>5,648,407,788.99</b>

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН  
2024 ОНЫ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Даатгалын үйл ажиллагаа</b>		
2	Даатгалын хураамжийн нийт орлого		472,939,269.06
3	Даатгалын хураамжийн буцаалт		(1,849,837.43)
4	Давхар даатгалын хураамжийн зардал		
<b>5</b>	<b>Даатгалын хураамжийн цэвэр орлого</b>		<b>471,089,431.63</b>
6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт		(313,277,943.45)
7	Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт		
<b>8</b>	<b>Орлогод тооцсон хураамж</b>		<b>157,811,488.18</b>
9	Нийт нөхөн төлбөр		1,053,200.00
10	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр		
11	Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр		
<b>12</b>	<b>Нөхөн төлбөрийн цэвэр зардал</b>		<b>1,053,200.00</b>
13	Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт		67,726,804.32
14	Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт		
15	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт		90,084,783.73
<b>16</b>	<b>Зардалд тооцсон нөхөн төлбөр</b>		<b>158,864,788.05</b>
17	Даатгалын гэрээний зардал		119,577,284.77
18	Давхар даатгалын шимтгэлийн орлого		
<b>19</b>	<b>Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>		<b>(120,630,584.64)</b>
20	Хүү, Эрхийн шимтгэлийн орлого		666,375,536.07
21	Бусад орлого		
23	Ерөнхий ба удирдлагын зардал		628,755,257.69
24	Борлуулалт, маркетингийн зардал		
25	Санхүүгийн зардал		196,100.00
26	Бусад зардал		34,738,455.96
27	Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз		
28	Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз		
<b>29</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>(117,944,862.19)</b>
30	Орлогын албан татварын зардал		(9,585,683.87)
<b>31</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>(108,359,178.32)</b>
32	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг(алдагдал)		
<b>33</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>(108,359,178.32)</b>
34	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
<b>35</b>	<b>Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү</b>		
36	Бусад		
<b>37</b>	<b>Орлогын нийт дүн</b>		<b>(108,359,178.32)</b>
38	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

Сүлд-Аудит ХХК

**ИНШУРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН  
2024 ОНЫ ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	НТК	Тогтвортой байдалын сан	Эзлийн өмчийн бусад хэсэг		Нийт дүн
					Хуримтлагдсан ашиг	(тоогаар)	
1	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	100,000.00					100,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-			100,000.00
4	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)				(108,359,178.32)		(108,359,178.32)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						
6	Өмчид гарсан өөрчлөлт	4,999,900,000.00			197,000,000.00		5,196,900,000.00
7	Зарласан ногдол ашиг						
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,000,000,000.00</b>			<b>197,000,000.00</b>	<b>(108,359,178.32)</b>	<b>5,088,640,821.68</b>

/Хавсаргасан тэмдэгтлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН  
2024 ОНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>391,349,211.63</b>
1.1.1	Даатгалын хураамжийн орлого		391,349,211.63
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>894,682,907.30</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн		315,475,684.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		87,692,127.68
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн		116,355,943.77
1.2.4	Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		
1.2.5	Нөхөн төлбөрт төлсөн		1,053,200.00
1.2.5.1	Үүнээс: Сайн дурын даатгалын		1,053,200.00
1.2.5.2	Албан журмын даатгалын		
1.2.6	Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		46,475,607.14
1.2.7	Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр		73,101,677.63
1.2.8	Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр		
1.2.9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		190,000.00
1.2.10	Татварын байгууллагад төлсөн		79,166,020.04
1.2.11	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.12	Бусад мөнгөн зарлага		175,172,646.19
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(503,333,695.67)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>6,306,398,763.81</b>
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		5,640,023,227.74
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		666,375,536.07
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>10,789,031,033.22</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		23,835,360.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд		18,150,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		10,747,045,673.22
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(4,482,632,269.41)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>5,196,900,000.00</b>
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас		4,999,900,000.00
3.1.4	Бусад		197,000,000.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>5,196,900,000.00</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>210,934,034.92</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>100,000.00</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>211,034,034.92</b>

/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно/

*Эрсдэлтүүтээр  
уратшижъя*



2205, 22<sup>nd</sup> floor, 1<sup>st</sup> Khoroo, Sukhbaatar District,  
Ulaanbaatar, Mongolia



+976 7711-1313



info@insurco.mn



www.insurco.mn